


БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА 
Ж.ГАНБААТАР

2022 оны 04 дүгээр сарын 04/11

УДИРДАМЖ

2022 оны 04 дүгээр сарын 04

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ хийх, ажлын үр дүнг
үнэлэх тухай

Зорилго: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор
батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон аймгийн
Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт
бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийх, нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал"-ын дагуу бодлогын баримт
бичгийн төлөвлөлтөд хяналт-шинжилгээ хийж, зөвлөгөө өгөх

Хугацаа: 2022 оны 04 дүгээр сарын 12-оос 2022 оны 04 дүгээр сарын 15-ны
хооронд багтаан явуулна.

Ажиллах багийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн

ахлагч: Ц.Ганчимэг

Гишүүд: Г.Уянга

Т.Бямбадулам

Б.Онончимэг

Б.Мөнгөнцэцэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
нутгийн захиргааны байгууллагын бодлого,
тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод
хяналт хариуцсан мэргэжилтэн

Архивын тасгийн дарга

Хамрах хүрээ: Баянхутаг, Галшар, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх сумдын
Засаг даргын Тамгын газрын дарга, мэргэжилтнүүд, сумын төсөвт
байгууллагуудын захирал, эрхлэгч, ажилтан, багийн Засаг дарга нар хамрагдана.

Хяналт- шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилт

2. Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
3. Байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хоорондын уялдаа
4. Төрийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал
5. Аймгийн Засаг даргын "Байгууллагын үйлчилгээний стандартын загвар батлах тухай" 2021 оны А/11, "Журам батлах тухай" А/168, Хяналтын хуудас хэрэглэх журам батлах тухай" А/340 дүгээр захирамжийн хэрэгжилттэй танилцах
6. Төрийн мэдээлэл солилцооны систем болон Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн хэрэгжилттэй танилцах
7. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт
8. Мэдээллийн ил тод байдал
9. Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх
10. Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн систем дэх шивэлтийг сайжруулах, анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хийх
11. Байгууллагын тамга, тэмдэг, баталгааны тэмдэгийн бүрэн бүтэн байдал, Тамга тэмдэг баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалалт хамгаалалт, хэвлэмэл хуудасны зарцуулалт, түүнд тавьж буй хяналт
12. Цахим албан хэрэг хөтлөлтийн байдал
 - Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэн үнэлгээ өгнө.
 - Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.
 - Хяналт-шинжилгээний дүнг удирдлагын зөвлөлд ажлын 7 хоногт багтаан танилцуулна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АГЕНТЛАГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.УЯНГА